

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/1/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261945 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn Аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ З.ЭНХБОЛД ТАНАА

2024.03.25 № 07/813
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 3,035.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Жилийн эцэст 444.4 сая төгрөгийн бараа материал, 12,588.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийж, баталгаажуулаагүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй;
- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7,782.9 сая төгрөгийн эд хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй;
- Цалин хөлс, үр дүнгийн урамшууллыг илүү тооцож, хавтгайруулан 263.0 сая төгрөг олгосон;
- Бараа материалын тайланд 362.4 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан, 89.3 сая төгрөгийн материалыг их хэмжээгээр нөөцөлсөн;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 172.8 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан;

- Худалдан авах ажиллагааны холбогдох журмыг зөрчиж 149.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулаагүй;
- Санхүүгийн тайланд илэрхийлсэн 124.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг барагдуулаагүй;
- Урьдчилж төлсөн зардлын 515.0 сая төгрөгийн ажил гүйлгээг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
- Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 257.4 сая төгрөгөөр тасалсан,
- Өмнөх аудитаар хүргүүлсэн 121.2 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй

зэрэг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, 34 дүгээр зүйлийн 34.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.2.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны Б/26, 2020 оны Б/36, 2023 оны Б/03, Б/32, Б/45 дугаар 5 удаагийн тушаалаар 2019 оноос хойш Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 5 албан тушаалтан томилогдож, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 92 дугаар тогтоол, Өмчийн харилцааны газрын 2023 оны 3/962 дугаар албан бичгийг үндэслэн Мэргэжлийн хяналтын газар /хуучнаар/ татан буугдсантай холбоотойгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон харьяа байгууллагад 102 албан хаагчийн орон тоо нэмэгдэж, 23.9 сая төгрөгийн 125 ширхэг бараа материал, 583.6 сая төгрөгийн 772 ширхэг тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжиж ирсэн байна.

Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 4 дүгээр тогтоолоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын аппаратын орон тооны дээд хязгаарыг 67 байхаар баталж, батлагдсан орон тоонд тусгагдаагүй 9 төрийн үйлчилгээний ажилтныг 2019 оноос хойш ажиллуулсаар байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 24 зорилтын 98 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас гүйцэтгэлээр 17 арга хэмжээг 100.0 хувь, 50 арга хэмжээг 90.0 хувь, 23 арга хэмжээг 70.0 хувь, 6 арга хэмжээг 50.0 хувь, 2 арга хэмжээг 30.0 хувь буюу нийт дүнгээр 83.4 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,053,818.8	2,139,639.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	68,548.3	176,247.9
33	АВЛАГА	492,830.4	486,105.3
34	УРЬДЧИЛГАА	13,000.0	32,600.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,479,440.2	1,444,686.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,182,181.7	45,408,758.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	42,182,181.7	45,408,758.4
39200	Биет хөрөнгө	36,707,852.8	37,651,256.1
39300	Биет бус хөрөнгө	5,474,328.9	7,757,502.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	44,236,000.5	47,548,397.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	35,193.9	46,438.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35,193.9	46,438.7
41300	Өглөг	35,193.9	46,438.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	44,200,806.6	47,501,959.2
51	Засгийн газрын хувь оролцоо	44,200,806.6	47,501,959.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	14,587,677.3	14,667,332.3
51200	Хуримтлагдсан үр дүн	23,515,477.5	26,769,451.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,097,651.8	6,065,175.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	44,236,000.5	47,548,397.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	35,177,673.8	59,090,706.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,130,774.8	11,050,494.8
120	Нийтлэг татварын бус орлого	4,130,774.8	11,050,494.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,046,899.1	48,040,211.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	37,573,182.0	55,493,083.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,573,182.0	55,493,083.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,750,217.8	51,604,541.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,859,014.6	34,436,901.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,577,643.1	4,174,021.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,085,285.4	2,621,738.7
2104	Хангамж, бараа материалын зардал	848,112.2	1,084,183.7
2105	Норматив зардал	803,623.6	894,057.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,663.5	167,701.7
2107	Томилолт, зочны зардал	99,847.7	219,055.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,510,175.1	2,708,293.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,830,852.7	5,298,589.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,822,964.2	3,888,541.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(2,395,508.2)	3,597,623.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	65,980.5	67.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	198,356.3	437,012.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(2,527,884.0)	3,160,678.1

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,728,821.3	46,728,821.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,448.0	21,448.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	46,750,269.3	46,750,269.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(23,492.7)	(23,492.7)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,914.0	1,914.0
9	Тайлант үеийн үр дүн	(2,527,884.0)	(2,527,884.0)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,200,806.6	44,200,806.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	93,295.7	93,295.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,294,102.3	44,294,102.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(32,476.1)	(32,476.1)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	79,655.0	79,655.0
19	Тайлант үеийн үр дүн	3,160,678.1	3,160,678.1
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,501,959.2	47,501,959.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	33,760,921.9	51,560,938.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,299,083.2	3,513,135.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,299,083.2	3,513,135.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,461,838.7	48,047,803.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,619,402.5	51,337,278.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,619,402.5	51,337,278.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,794,996.0	47,359,430.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,844,891.9	34,386,968.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,500,307.6	4,153,107.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,084,106.7	2,578,952.2
2104	Хангамж, бараа материалын зардал	694,933.9	955,012.0
2105	Нормативт зардал	832,802.8	882,084.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	168,764.1	232,012.4
2107	Томилолт, зочны зардал	100,357.7	212,653.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,632,184.8	2,807,404.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	936,646.5	1,151,235.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,824,406.5	3,977,848.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	141,519.4	223,659.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	112,249.6	95,961.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,249.6	95,961.1
2200	Дотоод эх үүсвэрээр	112,249.6	95,961.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(112,249.6)	(95,961.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(3,583.2)	(19,999.1)
14	Бусад эх үүсвэр	16,480.5	67.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	20,063.6	20,066.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	25,686.6	107,699.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,861.6	68,548.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,548.3	176,247.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,417,059,200.00	44,006,766,511.93	1,410,292,688.07	96.9
УРСГАЛ ЗАРДАЛ	45,417,059,200.00	44,006,766,511.93	1,410,292,688.07	96.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,750,226,800.00	43,453,238,702.93	1,296,988,097.07	97.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,386,368,000.00	33,743,254,080.02	643,113,919.98	98.1
Үндсэн цалин	20,400,548,200.00	19,045,066,479.95	1,355,481,720.05	93.4
Нэмэгдэл	11,314,796,900.00	8,498,170,620.38	2,816,626,279.62	75.1
Унаа хоолны хөнгөлөлт	1,323,632,200.00	3,648,798,369.79	(2,325,166,169.79)	275.7
Урамшуулал	1,347,390,700.00	2,541,527,301.30	(1,194,136,601.30)	188.6
Гэрээт ажлын хөлс	0.00	9,691,308.60	(9,691,308.60)	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,253,326,200.00	4,079,613,873.14	173,712,326.86	95.9
Тэтгэврийн даатгал	2,903,640,000.00	2,806,235,875.76	97,404,124.24	96.6
Тэтгэмжийн даатгал	337,443,300.00	328,525,028.80	8,918,271.20	97.4
ҮОМШӨ-ний даатгал	269,954,900.00	260,778,246.79	9,176,653.21	96.6
Ажилгүйдлийн даатгал	67,588,200.00	63,378,046.47	4,210,153.53	93.8
Эрүүл мэндийн даатгал	674,699,800.00	620,696,675.32	54,003,124.68	92.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,686,548,500.00	2,548,673,130.39	137,875,369.61	94.9
Гэрэл, цахилгаан	401,530,100.00	377,012,300.89	24,517,799.11	93.9
Түлш, халаалт	1,105,453,600.00	1,050,182,712.34	55,270,887.66	95.0
Цэвэр, бохир ус	173,196,500.00	139,932,675.76	33,263,824.24	80.8
Байрны түрээс	1,006,368,300.00	981,545,441.40	24,822,858.60	97.5
Хангамж, бараа материалын зардал	431,263,700.00	403,008,421.66	28,255,278.34	93.4
Бичиг хэрэг	95,608,200.00	99,457,479.08	(3,849,279.08)	104.0
Тээвэр, шатахуун	75,264,400.00	68,302,348.66	6,962,051.34	90.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,708,800.00	77,263,435.40	5,445,364.60	93.4
Ном, хэвлэл	600,000.00	-	600,000.00	0.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,361,600.00	10,558,330.00	4,803,270.00	68.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	161,720,700.00	147,426,828.52	14,293,871.48	91.2
Норматив зардал	935,488,400.00	850,304,165.72	85,184,234.28	90.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,944,200.00	13,079,415.00	5,864,785.00	69.0
Хоол, хүнс	876,407,900.00	806,749,619.72	69,658,280.28	92.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,136,300.00	30,475,131.00	9,661,169.00	75.9
Эд хогшил, урсгал засварын зардал	249,726,400.00	228,363,268.44	21,363,131.56	91.4
Багаж, техник, хэрэгсэл	84,531,500.00	75,111,929.00	9,419,571.00	88.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,854,200.00	2,482,000.00	1,372,200.00	64.4
Урсгал засвар	161,340,700.00	150,769,339.44	10,571,360.56	93.4
Томилолт, зочны зардал	64,107,600.00	59,414,691.95	4,692,908.05	92.7
Дотоод албан томилолт	60,607,600.00	55,954,591.95	4,653,008.05	92.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	3,500,000.00	3,460,100.00	39,900.00	98.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,672,718,000.00	1,471,047,606.41	201,670,393.59	87.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,369,794,200.00	1,178,981,680.42	190,812,519.58	86.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	123,226,600.00	123,057,000.00	169,600.00	99.9
Даатгалын үйлчилгээ	77,592,100.00	75,226,389.59	2,365,710.41	97.0
Тээврийн хэрэгслийн татвар	14,401,700.00	12,053,586.60	2,348,113.40	83.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,106,100.00	1,443,412.00	662,688.00	68.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,384,000.00	53,961,765.00	2,422,235.00	95.7

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Газрын төлбөр	20,745,800.00	19,864,320.00	881,480.00	95.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,140,100.00	2,132,052.80	2,008,047.20	51.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,327,400.00	4,327,400.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	70,680,000.00	69,559,465.20	1,120,534.80	98.4
Бараа үйлчилгээний бусад зардал	35,979,300.00	35,602,301.00	376,999.00	99.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,700,700.00	33,957,164.20	743,535.80	97.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	666,832,400.00	553,527,809.00	113,304,591.00	83.0
Бусад урсгал шилжүүлэг	666,832,400.00	553,527,809.00	113,304,591.00	83.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	-	500,000.00	0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	592,140,300.00	484,489,290.00	107,651,010.00	81.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	74,192,100.00	69,038,519.00	5,153,581.00	93.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,417,059,200.00	44,085,477,178.67	1,331,582,021.33	97.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,569,001,200.00	42,461,160,625.83	1,107,840,574.17	97.5
Улсын төсвөөс санхүүжих	43,569,001,200.00	42,461,160,625.83	1,107,840,574.17	97.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,848,058,000.00	1,624,316,552.84	223,741,447.16	87.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	164,350,000.00	198,047,500.80	(33,697,500.80)	120.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,683,708,000.00	1,426,269,052.04	257,438,947.96	84.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,296,076.30	(3,296,076.30)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	34	34	-	100.0
Төсвийн байгууллага	34	34	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,745	1,722	23	98.7
Удирдах ажилтан	35	35	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,401	1,378	23	98.4
Үйлчлэх ажилтан	309	309	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,572,826,265.94
УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,538,756,265.96
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,941,518,431.40
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	643,645,323.85
Үндсэн цалин	-	183,697,060.41
Нэмэгдэл	-	296,799,834.29
Унаа хоолны хөнгөлөлт	-	13,221,500.00
Урамшуулал	-	149,926,929.15
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	73,493,442.15
Тэтгэврийн даатгал	-	62,697,769.84
Тэтгэмжийн даатгал	-	2,906,299.98
ҮОМШӨ-ний даатгал	-	2,691,012.64
Ажилгүйдлийн даатгал	-	484,612.57
Эрүүл мэндийн даатгал	-	4,713,747.12
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	30,279,015.49
Гэрэл, цахилгаан	-	2,383,214.18
Түлш, халаалт	-	27,845,868.12
Цэвэр, бохир ус	-	49,933.19
Хангамж, бараа материалын зардал	-	556,698,225.74
Бичиг хэрэг	-	207,436,753.60
Тээвэр, шатахуун	-	282,735,794.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	35,409,471.14
Ном, хэвлэл	-	1,107,500.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	30,008,707.00
Нормативт зардал	-	31,784,790.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	29,380.00
Хоол, хүнс	-	31,755,410.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	53,118,250.00
Багаж, техник, хэрэгсэл	-	7,458,600.00
Урсгал засвар	-	45,659,650.00
Томилолт, зочны зардал	-	153,238,498.00
Гадаад албан томилолт	-	15,600,400.00
Дотоод албан томилолт	-	137,638,098.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,340,539,180.37
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,329,561,480.37
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,008,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	5,969,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,058,721,705.80
Бараа үйлчилгээний бусад зардал	-	872,780,913.80
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	185,940,792.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	597,237,834.56
Бусад урсгал шилжүүлэг	-	457,016,536.00
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	161,877,300.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	20,466,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	274,673,236.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	140,221,298.56
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	114,385,556.21
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,056,000.00
Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,779,742.35
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	34,069,999.98
Дотоод эх үүсвэрээр	-	34,069,999.98

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	34,069,999.98
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,572,826,265.94
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,572,826,265.94
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,109,679,160.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,094,500,309.63
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,164,281,859.31
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	204,364,937.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 байгууллагын тайланг нэгтгэснээс 26 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 3 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар-аппарат, Нийслэлийн ХХҮХ, Чингэлтэй дүүргийн ХХҮХ/ өгч, аудитын түүвэрт 5 байгууллага, 2 зардлын дансыг хамрууллаа.

Төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 3,035.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 559.3 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.1. Төвлөрүүлэн захирагч

3.1.1 Албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 36 байгууллагуудад хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, төсвийн зарцуулалттай холбоотой материаллаг хэмжээний 2,765.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагад илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.1.2. Зөвлөмж

1. Орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,683.7 сая төгрөгөөр батлагдсанаас 257.4 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 12 дугаар зүйлийн 12.1.17-д “төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг бууруулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;” 31 дүгээр зүйлийн 31.4.2-д “төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо”, 35 дугаар зүйлийн 35.2-д “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төсөвт байгууллагын орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллах.

2. Урьдчилгаа данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Өмнөговь аймгийн ХХҮГ-т өмнөх онд шилжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн программ хангамж хийлгэх ажлын урьдчилгаа 13.0 сая төгрөг шилжүүлснийг тайлант онд тухайн ажлыг хүлээн авах ажлыг зохион байгуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөр эрхлэлтийн программыг хүлээн авч, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 3,409.5 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 64 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ													
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар-ТТЗ	1	39,310.9			1	39,310.9	1	39,310.9				
	ТТЗ-ийн алдааны дүн	1	39,310.9			1	39,310.9	1	39,310.9				
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар-аппарат	4	2,341,947.8			4	2,341,947.8	4	2,341,947.8				
2	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	1	10,920.0			1	10,920.0	1	10,920.0				
3	БГД-ийн ХХҮХ	1	2,090.7			1	2,090.7	1	2,090.7				
4	БЗД-ийн ХХҮХ	3	81,974.7			3	81,974.7	3	81,974.7				
5	Булган аймгийн ХХҮГ	1	7,682.9			1	7,682.9	1	7,682.9				
6	Багахангай дүүргийн ХХҮГ	17	221,317.9	11	82,260.3	6	139,057.6	17	221,317.9				
7	Баян-Өлгийн аймгийн ХХҮГ	1	3,177.2			1	3,177.2	1	3,177.2				
8	Говь-Алтай аймгийн ХХҮГ	1	14,295.0	1	14,295.0			1	14,295.0				
9	Дорнод аймгийн ХХҮГ	3	192,518.8	1	114,300.0	2	78,218.8	3	192,518.8				
10	Дорноговь аймгийн ХХҮГ	2	8,449.6			2	8,449.6	2	8,449.6				
11	Дундговь аймгийн ХХҮГ	5	18,621.7			5	18,621.7	5	18,621.7				
12	Нийслэл дүүргийн ХХҮХ	3	38,514.5			3	38,514.5	3	38,514.5				
13	Орхон аймгийн ХХҮГ	1	328.3			1	328.3	1	328.3				
14	СБД-ийн ХХҮХ	1	13,628.0	1	13,628.0			1	13,628.0				
15	СХД-ийн ХХҮХ	3	25,968.5			3	25,968.5	3	25,968.5				
16	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	1	750.0			1	750.0	1	750.0				
17	Хан-Уул дүүргийн ХХҮГ	4	77,337.0	4	77,337.0			4	77,337.0				
18	Хөвсгөл аймгийн ХХҮГ	1	79,655.0	1	-	1	79,655.0	1	79,655.0				
19	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	7	213,557.1	1	1,556.4	6	212,000.7	7	213,557.1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	Өвөрхангай аймгийн ХХҮГ	2	17,430.0			2	17,430.0	2	17,430.0				
21	Өмнөговь аймгийн ХХҮГ	1	0.2			1	0.2	1	0.2				
	Харьяа байгууллагуудын алдааны дүн	63	3,370,164.9	20	303,376.7	44	3,066,788.2	63	3,370,164.9	0	-	0	-
	Нийт алдааны дүн	64	3,409,475.8	20	303,376.7	45	3,106,099.1	64	3,409,475.8	0	-	0	-

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитаар нийт 3,035.8 сая төгрөгийн 87 зөрчил² илэрснээс, 151.4 сая төгрөгийн 15 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 274.9 сая төгрөгийн 17 зөрчилд албан шаардлага хүргүүлж, үүнээс 105.9 сая төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага, 2,503.6 сая төгрөгийн 54 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын дүгнэлт				Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
			Үүнээс:						Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ																
1	ХХҮЕГ-ТТЗ	СНАГ-2024/01/НА-СТА-ТТЗ	1		1		3	270,438.9			1	-			2	270,438.9
ТТЗ-ийн зөрчлийн дүн			1	-	1	-	3	270,438.9	-	-	1	-	-	-	2	270,438.9
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ																
1	ХХҮЕГ-аппарат	СНАГ-2024/70/НА-СТА-ТШЗ	1		1		14	1,391,433.1			5	224,833.9	1	105,882.8	8	1,060,716.4
2	Архангай аймгийн ХХҮГ	АРА-2024/07-НА-СТА-ТШЗ	1	1			2	11,659.2			2	11,659.2				
3	БНСУ дахь ХНХҮТ	СНАГ-2024/76/НА-СТА-ТШЗ	1			1	3	124,761.0	1	124,761.0					2	-
4	БГД-ийн ХХҮХ	НТАГ-2024/56/НА-СТА-ТШЗ	1	1			2	5,401.5							2	5,401.5
5	БЗД-ийн ХХҮХ	НТАГ-2024/54/НА-СТА-ТШЗ	1	1			5	11,616.7			1	6,616.3			4	5,000.4
6	БНД-ийн ХХҮХ	НТАГ-2024/62/НА-СТА-ТЗШ	1	1			0	-								
7	Булган аймгийн ХХҮГ	БУА-2023/06/НА-СТА-ТШЗ	1	1			1	2,399.6							1	2,399.6
8	Баянхонгор аймгийн ХХҮГ	БНА-2024/06/НА-СТА-ТШЗ	1			1	0	-								
9	БХД-ийн ХХҮХ	НТАГ-2024/59/НА-СТА-ТШЗ	1	1			6	6,970.1	1	797.6					5	6,172.5
10	Баян-Өлгий аймгийн ХХҮГ	БӨА-2024/06/НА-СТА-ТШЗ	1			1	1	50.0	1	50.0						
11	Говь-Алтай аймгийн ХХҮГ	ГАА-2024/07/НА-СТА-ТШЗ	1	1			5	7,238.1	2	1,626.1	1	542.0			2	5,070.0
12	Говь-Сүмбэр аймгийн ХХҮГ	ГСА-2024/06/НА-СТА-ТШЗ	1	1			1	448.0				-			1	448.0
13	Дархан-Уул аймгийн ХХҮГ	ДАА-2024/06/НА-СТА-ТШЗ	1	1			3	6,864.3	1	1,910.8	2	4,953.5				
14	Дорнод аймгийн ХХҮГ	ДОА-2024/07/НА-СТА-ТШЗ	1	1			2	5,609.0	1	456.0	1	5,153.0				
15	Дорноговь аймгийн ХХҮГ	ДГА-2024/08НА-СТА-ТШЗ	1	1			3	-							3	-
16	Дундговь аймгийн ХХҮГ	ДУА-2024/09НА-СТА-ТШЗ	1	1			0	-								
17	Завхан аймгийн ХХҮГ	ЗАА-2024//11//НА-СТА-ТШЗ	1	1			1	2,286.7							1	2,286.7
18	Налайх дүүргийн ХХҮХ	НТАГ-2024/52/НА-СТА-ТШЗ	1	1			1	4,202.0							1	4,202.0
19	Нийслэлийн ХХҮХ	НТАГ-2024/48/НА-СТА-ТШЗ	1		1		4	223,231.8							4	223,231.8
20	Орхон аймгийн ХХҮГ	ОРА-2024/05/НА-СТА-ТШЗ	1	1			5	7,979.4	3	4,224.6					2	3,754.8

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	Ор.ХХҮГ. Ахмадын сан	ОРА-2024/05/НА-СТА-ТШЗ	1			1	0	-								
22	СБД-ийн ХХҮХ	НТАГ-2024/54/НА-СТА-ТШЗ	1	1			2	2,501.3						2	2,501.3	
23	СХД-ийн ХХҮХ	НТАГ-2024/43/НА-СТА-ТШЗ	1	1			3	14,687.3						3	14,687.3	
24	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	СЭА-2024/250/НА-СТА-ТШЗ	1	1			2	13,023.1	1	10,773.1	1	2,250.0				
25	Сүхбаатар аймгийн ХХҮГ	СБА-2024/07/НА-СТА-ТШЗ	1			1	1	-						1	-	
26	Төв аймгийн ХХҮГ	ТӨА-/05/2024-НА-СТА-ТШЗ	1	1			3	104,463.8			1	5,208.0		2	99,255.8	
27	Увс аймгийн ХХҮГ	УВА-2024/06/НА-СТА-ТШЗ	1	1			1	650.1	1	650.1						
28	Ховд аймгийн ХХҮГ	ХОА-2024/08/НА-СТА-ТШЗ	1	1			0	-								
29	Хан-Уул дүүргийн ХХҮГ	ННТАГ-2024/36/НА-СТА-ТШЗ	1	1			1	6,617.0						1	6,617.0	
30	Ху.ХХҮХ. Ахмадын сан	ННТАГ-2024/36/НА-СТА-ТШЗ	1			1	0	-								
31	Хэнтий аймгийн ХХҮГ	ХЭА-2024/09/НА-СТА-ТШЗ	1	1			1	624.0	1	624.0						
32	Хөвсгөл аймгийн ХХҮГ	ХӨА-2024/05/НА-СТА-ТШЗ	1	1			1	1,422.7						1	1,422.7	
33	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	НТАГ-2024/32/НА-СТА-ТШЗ	1		1		8	807,764.6	2	5,568.0	1	12,229.4		5	789,967.2	
34	Япон улс дахь ХНХҮТ	СНАГ-2024/52/НА-СТА-ТШЗ	1			1	0	-								
35	Өвөрхангай аймгийн ХХҮГ	ӨВА-2024/121/НА-СТА-ТШЗ	1	1			0	-								
36	Өмнөговь аймгийн ХХҮГ	ӨМА-2024/105/НА-СТА-ТШЗ	1	1			2	1,430.0			1	1,430.0		1	-	
Харьяа байгууллагуудын зөрчлийн дүн			36	26	3	7	84	2,765,334.4	15	151,441.3	16	274,875.3	1	105,882.8	52	2,233,135.0
НИЙТ ЗӨРЧЛИЙН ДҮН			37	26	4	7	87	3,035,773.3	15	151,441.3	17	274,875.3	1	105,882.8	54	2,503,573.9

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3,348.9 сая төгрөгийн 36 зөрчил илэрснээс 1,736.6 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 1,612.3 сая төгрөгийн 27 зөвлөмж өгсөн.

Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ							
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар-ТТЗ	2	-	1	-	1	-
	ТТЗ-ийн дүн	2	-	1	-	1	-
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар-аппарат	4	-			4	-
2	Архангай аймгийн ХХҮГ	1	-	1	-		
3	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	8	-	1	-	7	-
4	БГД-ийн ХХҮХ	2	-			2	-
5	БЗД-ийн ХХҮХ	2	505,794.9	1	505,794.9	1	-
6	Багахангай дүүргийн ХХҮХ	2	4,243.5			2	4,243.5
7	Багануур дүүргийн ХХҮХ	1	672,984.6			1	672,984.6
8	Баян-Өлгий аймгийн ХХҮГ	1	193,875.4	1	193,875.4		
9	Говь-Алтай аймгийн ХХҮГ	1	-	1	-		
10	Говь-Сүмбэр аймгийн ХХҮГ	2	167,394.0	1	167,394.0	1	-
11	Дорнод аймгийн ХХҮГ	1	-			1	-
12	Дорноговь аймгийн ХХҮГ	1	869,506.5	1	869,506.5		
13	Дундговь аймгийн ХХҮГ	1	-			1	-
14	Налайх дүүргийн ХХҮХ	1	-			1	-
15	Орхон аймгийн ХХҮГ	1	-	1	-		
16	СБД-ийн ХХҮХ	1	494,469.8			1	494,469.8
17	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	1	-			1	-
18	Хан-Уул дүүргийн ХХҮГ	2	427,870.5			2	427,870.5
19	Өмнөговь аймгийн ХХҮГ	1	12,757.5			1	12,757.5
	Харьяа байгууллагуудын дүн	34	3,348,896.7	8	1,736,570.8	26	1,612,325.9
	Нийт дүн	36	3,348,896.7	9	1,736,570.8	27	1,612,325.9